



**УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖААНЫ
ТОЙМ - 2026 ОНЫ II ДУГААР УЛИРАЛ**


МХБ-ээр арилжигдсан уул уурхайн бүтээгдэхүүний 2026 оны II дугаар улирлын арилжааны тойм

2026 оны II дугаар улиралд нийт 282 удаагийн цахим дуудлага арилжаа зохион байгуулагдсанаас 229 арилжааны хэлцэл амжилттай хийгдэж, нийт 10.11 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 3.53 их наяд төгрөгөөр арилжааллаа. “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан “Андын Илч ХХК”, “Монголын Алт (МАК) ХХК”, “Мөнх тэнүүн оргил ХХК”, “Саусгоби Сэндс ХХК”, “Тавантолгой ХК”, “Хангад Эксплорэйшн ХХК”, “Энержи Ресурс ХХК”, “Эрдэнэс Тавантолгой ХК” нь 8.36 сая тонн нүүрсийг 2.89 их наяд төгрөгөөр, “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК”, “Эрдэнэс критикал минералс ТӨҮГ /Монголросцветмет ТӨҮГ/” нь 1.72 сая тонн төмрийн хүдэр, баяжмалыг 393.26 тэрбум төгрөгөөр, “Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ” нь 24.0 мянган тонн зэсийн баяжмалыг 249.37 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалсан байна.

	Хэлцэл	Тоо хэмжээ тн	Үнийн дүн ₮
Нүүрс	176	8,358,400	2,887,239,749,254
Төмөр	50	1,723,800	393,258,848,025
Зэс	3	24,000	249,373,146,358
НИЙТ	229	10,106,200	3,529,871,743,638

Нийт арилжааны хэмжээний бүтцийн хувьд 82.71% -ийг нүүрс, 17.06% -ийг төмрийн хүдэр болон баяжмал, 0.24% -ийг зэсийн баяжмалын арилжаа тус тус, нийт арилжааны дүнд нүүрс 81.79%, төмрийн хүдэр болон баяжмал 11.14%, зэсийн баяжмал 7.06% -ийг тус тус эзэлж байна.

График 1. Нийт уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны тоо хэмжээнд эзлэх хувь.




1. Нүүрсний арилжаа

Тайлант хугацаанд нийт 176 удаагийн нүүрсний дуудлага арилжаа амжилттай хэлцэл хийгдэж, 8.36 сая тонн нүүрсийг 2.89 их наяд төгрөгөөр арилжсан байна. Дуудлага худалдаагаар арилжсан нүүрсний үнийн өсөлтийн дундаж 9.32% байгаа бөгөөд худалдагч компаниуд уг үнийн өсөлтөөс нийт 210.16 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон байна.

Хүснэгт 1. Нийт арилжигдсан нүүрсний хэмжээ, үнийн дүн.


№	Бүтээгдэхүүний ангилал	Тоо хэмжээ тн	Үнийн дүн ₮
1	1/3 коксжих нүүрс	3,084,800	1,037,275,364,768
2	Дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс	1,299,200	594,113,148,032
3	Баяжуулсан сул коксжих нүүрс	1,107,200	464,915,680,902
4	Эрчим хүчний нүүрс /Битумт, үл барьцалдах нүүрс/	896,000	206,877,345,024
5	Баяжуулсан коксжих чанаргүй нүүрс	601,600	146,757,393,184
6	Баяжуулсан дунд зэрэг үнстэй, хагас хатуу коксжих нүүрс	480,000	118,762,966,080
7	Баяжуулсан коксжих нүүрс	473,600	246,728,722,560
8	Дэгдэмхий бодис их, хийн нүүрс	204,800	35,624,202,240
9	Эрчим хүчний нүүрс /Саб-битумт, сул барьцалдах нүүрс/	153,600	31,951,998,464
10	Чийг багатай хүрэн нүүрс	57,600	4,232,928,000
НИЙТ		8,358,400	2,887,239,749,254

График 2. Нийт нүүрсний арилжааны үнийн дүнд эзлэх хувь /бүтээгдэхүүний ангилаар/.



Нийт нүүрсний арилжааны үнийн дүнгийн 35.93 хувь буюу 1.04 их наяд төгрөгийг 1/3 коксжих нүүрсний арилжаа, 20.58 хувь буюу 594.11 тэрбум төгрөгийг дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрсний арилжаа, 16.10 хувь буюу 464.92 тэрбум төгрөгийг баяжуулсан сул коксжих нүүрсний арилжаа, 8.55 хувь буюу 246.73 тэрбум төгрөгийг баяжуулсан коксжих нүүрсний арилжаа, 7.17 хувь буюу 206.88 тэрбум төгрөгийг эрчим хүчний нүүрс /битумт, үл барьцалдах нүүрс/-ний арилжаа, 5.08 хувь буюу 146.76 тэрбум төгрөгийг баяжуулсан коксжих чанаргүй нүүрсний арилжаа, 4.11 хувь буюу 118.76 тэрбум төгрөгийг баяжуулсан дунд зэрэг үнстэй, хагас хатуу коксжих нүүрсний арилжаа, 1.23 хувь буюу 35.62 тэрбум төгрөгийг дэгдэмхий бодис их, хийн нүүрсний арилжаа, 1.11 хувь буюу 31.95 тэрбум төгрөгийг эрчим хүчний нүүрс /саб-битумт, сул барьцалдах нүүрс/-ний арилжаа, 0.15 хувь буюу 4.23 тэрбум төгрөгийг чийг багатай хүрэн нүүрсний арилжаа тус тус эзэлж байна.

График 3. Нийт нүүрсний арилжааны үнийн дүнд эзлэх хувь /худалдагч компаниар/.



Нүүрсний арилжааны нийт үнийн дүнгийн 58.47 хувь буюу 1.69 их наяд төгрөгийн арилжааг “Эрдэнэс Тавантолгой” ХК, 25.84 хувь буюу 746.09 тэрбум төгрөгийн арилжааг “Тавантолгой” ХК, 12.66 хувь буюу 365.49 тэрбум төгрөгийн арилжааг “Энержи Ресурс” ХХК, 1.23 хувь буюу 35.62 тэрбум төгрөгийн арилжааг “Саусгоби Сэндс” ХХК, 0.97 хувь буюу 27.95 тэрбум төгрөгийн арилжааг “Мөнх Тэнүүн Оргил” ХХК, 0.46 хувь буюу 13.38 тэрбум төгрөгийн арилжааг “Монголын Алт (МАК)” ХХК, 0.21 хувь буюу 6.16 тэрбум төгрөгийн арилжааг “Хангад Эксплорэйшн” ХХК, 0.15 хувь буюу 4.23 тэрбум төгрөгийн арилжааг “Андын Илч” ХХК тус тус эзэлж байна.


2. Төмрийн хүдэр, баяжмалын арилжаа

Тайлант хугацаанд нийт 50 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын дуудлага арилжаан амжилттай хэлцэл хийгдэж, 1.72 сая тонн төмрийн хүдэр, баяжмалыг 393.26 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Дуудлага худалдаагаар арилжсан төмрийн хүдэр, баяжмалын үнийн өсөлтийн дундаж 4.11 % байсан бөгөөд үнийн өсөлтийн үр дүнд худалдагч компаниуд нийт 6.95 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон байна.

Хүснэгт 2. Нийт арилжигдсан төмрийн хүдэр, баяжмалын хэмжээ, үнийн дүн.


Бүтээгдэхүүний ангилал	Тоо хэмжээ тн	Үнийн дүн ₮
Fe-58% Төмрийн баяжмал	1,301,400	278,206,279,317
Fe-52% Төмрийн хүдэр	323,400	82,244,415,495
Fe-65% Төмрийн баяжмал	99,000	32,808,153,213
НИЙТ	1,723,800	393,258,848,025

График 4. Нийт төмрийн хүдэр, баяжмалын арилжааны үнийн дүнд эзлэх хувь /бүтээгдэхүүний ангиллаар/.



Нийт төмрийн хүдэр, баяжмалын арилжааны үнийн дүнгийн 70.74 хувь буюу 278.21 тэрбум төгрөгийг Fe-58% төмрийн баяжмалын арилжаа, 20.91 хувь буюу 82.24 тэрбум төгрөгийг Fe-52% төмрийн хүдрийн арилжаа, 8.34 хувь буюу 32.81 тэрбум төгрөгийг Fe-65% төмрийн баяжмалын арилжаа тус тус эзэлж байна.

График 5. Нийт төмрийн хүдэр, баяжмалын арилжааны үнийн дүнд эзлэх хувь /худалдагч компаниар/.



Төмрийн хүдэр, баяжмалын арилжааны нийт үнийн дүнгийн 70.74 хувь буюу 278.21 тэрбум төгрөгийн арилжааг “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК, 29.26 хувь буюу 115.05 тэрбум төгрөгийн арилжааг “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ (хуучнаар “Монголросцветмет” ТӨҮГ) тус тус эзэлж байна.

3. Зэсийн баяжмалын арилжаа

Тайлант хугацаанд нийт 3 удаагийн зэсийн баяжмалын арилжаа амжилттай хэлцэл хийгдэж, “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ нь 24.0 мянган тонн зэсийн баяжмалыг 249.37 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Дуудлага худалдаагаар арилжсан зэсийн баяжмалын үнэ дунджаар 2.51 % -иар өссөн бөгөөд үүний үр дүнд худалдагч компани 6.09 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон байна.

Өмнөх улиралтай харьцуулсан үзүүлэлт

Хүснэгт 3. Өмнөх улиралтай харьцуулсан үзүүлэлт.

Үзүүлэлт	I улирал	II улирал	Өөрчлөлт
Амжилттай арилжаа	212	229	8.02%
Арилжааны хэмжээ тн	7,589,000	10,106,200	33.17%
Арилжааны үнийн дүн ₮	2,369,838,973,140	3,529,871,743,638	48.95%

Бүтээгдэхүүн	I улирал (тэрбум ₮)	II улирал (тэрбум ₮)	Өөрчлөлт
Нүүрс	1,914.0	2,887.2	50.85%
Төмөр	295.7	393.3	33.01%
Зэс	160.2	249.4	55.68%
Нийт абсолют өсөлт		1160.0 (тэрбум ₮)	

2026 оны II улиралд уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны хэмжээ өмнөх улиралтай харьцуулахад 33.17 хувь, үнийн дүн 48.95 хувиар өссөн байна. Үнийн дүнгийн өсөлтөд нүүрсний арилжаа голлох нөлөө үзүүлсэн бөгөөд төмрийн хүдэр, баяжмал болон зэсийн баяжмалын арилжааны үнийн дүн мөн өмнөх улирлаас өссөн үзүүлэлттэй байна.

2026 оны эхний хагас жил /өссөн дүнгээр/

2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт 515 удаагийн цахим дуудлага арилжаа зохион байгуулагдсанаас 441 арилжааны хэлцэл амжилттай хийгдэж, нийт 17.70 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 5.90 их наяд төгрөгөөр арилжааллаа.

Нүүрс - нийт 319 удаагийн нүүрсний дуудлага арилжаа амжилттай хэлцэл хийгдэж, 14.60 сая тонн нүүрсийг 4.80 их наяд төгрөгөөр арилжсан байна. Дуудлага худалдаагаар арилжсан нүүрсний үнийн өсөлтийн дундаж 9.51 % байгаа бөгөөд худалдагч компаниуд уг үнийн өсөлтөөс нийт 403.42 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон байна.

Төмрийн хүдэр, баяжмал - нийт 117 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын дуудлага арилжаан амжилттай хэлцэл хийгдэж, 3.05 сая тонн төмрийн хүдэр, баяжмалыг 688.93 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Дуудлага худалдаагаар арилжсан төмрийн хүдэр, баяжмалын үнийн өсөлтийн дундаж 3.85 % байсан бөгөөд үнийн өсөлтийн үр дүнд худалдагч компаниуд нийт 13.11 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон байна.

Зэсийн баяжмал - нийт 5 удаагийн зэсийн баяжмалын арилжаа амжилттай хэлцэл хийгдэж, 40.0 мянган тонн зэсийн баяжмалыг 409.55 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Дуудлага худалдаагаар арилжсан зэсийн баяжмалын үнэ дундажар 1.77 % -иар өссөн бөгөөд үүний үр дүнд худалдагч компани 7.13 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖАА, БҮРТГЭЛИЙН ГАЗАР